



АРХИВЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 06 сарын 06 өдөр

Дугаар 5/67

Улаанбаатар хот

Н.Дариймаад сахилгын шийтгэл  
ногдуулах тухай

Хөдөлмөрийн тухай хуулийн 131 дүгээр зүйлийн 131.1.1 дэх заалт, Захиргааны ерөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 26.1 дэх заалт, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8.3.5 дахь заалт, Хөдөлмөрийн гэрээний 8.1.1, 8.1.4 дэх заалт, Байгууллагын дотоод журмын 4.2.2, 8.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Архивын ерөнхий газрын Дэд даргын туслах, олон нийт, хэвлэл мэдээллийн асуудал хариуцсан ажилтан Наранцэцэгийн Дариймаа нь удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг хангалтгүй биелүүлж, ажилдаа хариуцлагагүй хандан, тавдугаар сарын эхэнд Хууль зүй, дотоод хэргийн яаманд албан бичгээр хүргүүлэх инфографик мэдээг 2018 оны 05 дугаар сарын 14 хүртэл хугацаа хоцроосон тул сахилгын сануулах шийтгэл ногдуулсугай.

2. Дээрх зөрчлийг давтан гаргасан тохиолдолд дараагийн шатны сахилгын арга хэмжээ авахыг Н.Дариймаад сануулсугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны удирдлагын газрын даргын үүргийг түр хавсран гүйцэтгэгч Ч.Оюунчимэгт даалгасугай.

ДАРГА



Д.ХОРОЛДАМБА

Tushaal

353110388